



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 425

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн албан ажлын хэрэгцээнд зориулан 27,000,000.00 (хорин долоон сая) төгрөгт багтаан автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн захирал Д.Баттогтоход дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 09 дугаар сарын 08-ны
өдрийн 125 дугаар тогтоолын хавсралт

**Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн худалдан авах
автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар**

| Д/д | Автомашины техникийн үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Худалдан авах үнийн дээд хязгаар |
|-----|--|-------------|------------|---|
| 1 | Суудлын автомашин /суудлын тоо 10, 2700 cc хөдөлгүүрийн багтаамжтай/ | ш | 1 | 27,000,000.00 |
| | Нийт үнэ | | 1 | 27,000,000.00 (хорин долоон сая) |